



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 30

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Аймгийн Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 1,007,080 (нэг сая долоон мянга наяд) төгрөгийн балансын үнэ, 480,413.28 (дөрвөн зуун наяд мянга дөрвөн зуун арван гурван төгрөг хорин найм) мөнгөний элэгдэл бүхий хавсралтад тусгасан хөрөнгийг балансаас балансад холбогдох байгууллагуудад шилжүүлсүгэй.

Хоёр: Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга Ц.Эрдэнэсүрэн, Сайнцагаан сумын “Эрдмийн далай” цогцолбор сургуулийн захирал Т.Туяамандах, Их газрын чулуу байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга Р.Баттүвшин нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 04-р сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.СҮХБААТАР



480219066

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 04 дүгээр сарын
02 өдрийн 10 тогтоолын 7 хавсралт

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН
МЭДЭЭЛЭЛ**

№	Хөрөнгий н нэр	Ашиглалтанд орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдса н элэгдэл	Үлдэгдэл өртөг	Хүлээн авах байгууллага
1	Даралтат хөгжим	2016.12.31	ш	1	790,000	790,000	263,333.28	526,666.72	1-р сургууль
3	Сейф	1989.12.30	ш	1	217,080	217,080	217,080.00	-	Их газрын чулуу БЦГХамгаалалтын захиргаа
ДҮН									
					1,007,080 /нэг сая долоон мянга наян төгрөг/	480,413.28 /дөрвөн зуун наян мянга дөрвөн зуун арван гурван төгрөг хорин найман мөнгө/	526,666.72 /таван зуун хорин зургаан мянга зургаан зуун жаран зургаан төгрөг далан хоёр мөнгө/		